

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... - ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг:

“6.2. Тусгай хамгаалалттай Дархан цаазат Богдхан уулын газар нутаг дэвсгэрт байгаа энэ хуулийн 4.1.4-д заасан татвар төлөгчөөс үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 1m^2 талбайд 1000 төгрөгөөр тооцож ногдуулна.

6.3. Тусгай хамгаалалттай Дархан цаазат Богдхан уулын газар нутаг дэвсгэрт байгаа энэ хуулийн 4.1.4-д зааснаас бусад татвар төлөгчөөс үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 1m^2 талбайд 3000 төгрөгөөр ногдуулна.”

2/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:

“7.3. Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт байгаа үл хөдлөх хөрөнгөнд энэ хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.74, 7.1.5 дахь заалт нь энэ хуулийн 6.2, 6.3 дахь хэсэгт хамаарахгүй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... - ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.2.8 дахь заалт:

"7.2.8. Тусгай хамгаалалттай Дархан цаазат Богдхан уулын газар нутаг дэвсгэрт байгаа Үл хөдлөх эд хөрөнгөд ногдуулсан албан татварын орлого;"

2/7 дугаар зүйлийн 7.3.12 дахь заалт:

"7.3.12 Тусгай хамгаалалттай дархан цаазат Богдхан уулын хязгаарлалтын бүсийн байгаль орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, нехэн сэргээх, хохирол тооцох, хууль хэрэгжүүлэх бусад зардал гаргах, дэмжлэг үзүүлэх."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...- ны өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1 дахь хэсэг:

“7.1. Дархан цаазат Богдхан уулын газар нутаг дэвсгэрт Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвартай байна. Албан татварыг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулиар зохицуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг